

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭД СУРГАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд зориулсан сургалт зохион байгуулагчид тавигдах шаардлага, сургалт зохион байгуулахтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Сургалтын үйл ажиллагаа нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг мэргэшүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт зөрчигдөхөөс сэргийлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУРГАЛТ, СУРГАЛТЫН БҮТЭЦ

2.1 Энэ журамд “сургалт” гэж Хороо дангаар болон сургалт зохион байгуулагчтай хамтран зохион байгуулж байгаа мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд зориулсан мэргэшүүлэх, захиалгат болон бусад сургалтыг ойлгоно.

2.2 Энэ журмын 2.1-д заасан сургалтыг Хороотой сургалт зохион байгуулах гэрээ байгуулсан сургалт зохион байгуулагчид эрхлэн явуулна.

2.3 Хороо болон сургалт зохион байгуулагч нь дараах төрлийн сургалтыг зохион байгуулна. Үүнд:

2.3.1 мэргэшүүлэх

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасны дагуу мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэх удирдлага, менежерт холбогдох хууль тогтоомж, Хорооноос гаргасан эрх зүйн акт, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар мэдээлэл өгөх, мэдлэгийг гүнзгийрүүлэх сургалтыг ойлгоно.

2.3.2 захиалгат болон бусад сургалт

Сургалт зохион байгуулагч болон бусад этгээдээс Хороонд бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу зохион байгуулах сургалтыг ойлгоно.

2.4 Сургалт зохион байгуулагч нь сургалтыг танхим, цахим болон эдгээрийг хосолсон хэлбэрээр зохион байгуулж болох бөгөөд сургалтын үргэлжлэх хугацаа гурван өдрөөс илүүгүй байна.

2.5 Сургалт зохион байгуулагч нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулна.

2.6 Сургалтын бүтэц:

2.6.1 Сургалтыг кредит цагаар хэмжинэ. Нэг кредит цаг 45 минут байна.

2.6.2 Сургалтын агуулга 16-аас доошгүй кредит цаг байна.

2.6.3 Сургалт танхимын болон цахим, эдгээрийн хосолсон хэлбэртэй байна.

2.6.3.1 Танхимын сургалтын оролцогчийн тоо 25-аас доошгүй, 40-өөс ихгүй байна.

2.7 Шалгалт:

2.7.1 Шалгалт сорилго /тест/-ын хэлбэртэй.

2.7.2 Сорилго нийт 40 асуулттай, үргэлжлэх хугацаа 60 минут байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

3.1. Сургалт зохион байгуулагчид дараах шаардлага хангасан байна ~~на~~. Үүнд:

3.1.1. сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавх бүхий сургагч багштай байх;

3.1.2. сургалт зохион байгуулах танхим, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх;

3.1.3. сургалтын үйл ажиллагаа эрхлэх журамтай байх;

3.1.4. батлагдсан орон тоо бүхий сургалтын нэгж эсхүл сургалтын асуудал хариуцсан орон тооны ажилтантай байх;

3.1.5. сургалтын чиглэлээр 5-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх;

3.1.6. мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй ашиг сонирхлын зөрчилгүй байх;

3.1.7. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийг тодорхойлох бусад шалгуурыг хангасан байх.

3.2. Сургалтыг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулахаар гэрээнд тусгана.

3.3. Сургалтын төлбөрийг сургалт зохион байгуулагч Хороотой байгуулсан сургалт зохион байгуулах гэрээнд тусгана.

3.5. Сургалт зохион байгуулагч нь сургалт зохион байгуулах хугацаа, сургалтын хэлбэр, давтамж, агуулга зэргийг багтаасан хөтөлбөрийн төслийг боловсруулж, сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн өдрөөс ажлын 15 хоногийн өмнө Хороонд ирүүлнэ.

3.6. Сургалт зохион байгуулагч нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 1 жилийн дотор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэх удирдлага, менежерт үнэ төлбөргүй сургалтыг зохион байгуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТАВИХ ШААРДЛАГА

4.1. Сургалт зохион байгуулагч дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Сургалт зохион байгуулагч сургалтын зарыг өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлж, тус сургалтад хамрагдах хүсэлтээ ирүүлсэн оролцогчийн бүртгэлийг

Хавсралт 1-д заасны дагуу бүртгэнэ. Сургалтын бүртгэлтэй холбоотой асуудлыг сургалт зохион байгуулагч шийдвэрлэнэ.

4.1.2. Мэргэшүүлэх болон захиалгат, бусад сургалт нь төлбөртэй байх бөгөөд төлбөрийн хэмжээг сургалт зохион байгуулагч Хороотой байгуулсан сургалт зохион байгуулах гэрээнд нийцүүлэн тогтооно.

4.1.3 Сургалтын төлбөр зөвхөн тухайн сургалтын сургагч багшийн төлбөр, гарын авлага, тараах материал, сургалтын танхим, тоног төхөөрөмж, шалгалтын үйл ажиллагаанд зарцуулагдана.

4.1.4. Сургалтын гарын авлага нь хууль эрх зүйн болон цаг үеийн шинэлэг мэдээллийг тусгасан мэргэшүүлэх, бие даан суралцах боломж бүхий ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн байна.

4.1.5. Сургалтад заавал хамрагдах үүрэгтэй этгээд сургалтад хамрагдаагүй бол сургалт зохион байгуулагчаас ирсэн мэдээллийг үндэслэн Хорооны сургалт хариуцсан нэгжээс тухайн үйл ажиллагааг хариуцсан нэгжид мэдээллийг хүргүүлнэ.

4.2. Сургалт зохион байгуулагч нь дараах мэдээллийг багтаасан сургалтын тайланг сургалт дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан Хороонд ирүүлнэ. Үүнд:

4.2.1. сургалтын хөтөлбөр;

4.2.2. оролцогчдын бүртгэл болон гарын үсгээр баталгаажсан сургалтын ирц;

4.2.3. сургагч багшийн мэдээлэл;

4.2.4. гарын авлага;

4.2.5. сургалтад оролцогчдын сэтгэл ханамжийн судалгаа, нэгтгэл

4.3. Хороо дараах үүргийг хэрэгжүүлнэ:

4.3.1. сургалтын хөтөлбөрт шаардлагатай сургалтын сэдвийг агуулсан эсэх, сургагч багшийн мэдээлэл, үргэлжлэх хугацаа зэргийг хянаж, баталгаажуулан ажлын 5 хоногт багтаан Сургалт зохион байгуулагчид хариу хүргүүлнэ.

4.1.2. сургалтын хөтөлбөрийг тухайн эрхлэх үйл ажиллагааны чиглэл тус бүрээр Хавсралт 2-т заасан маягтын дагуу хянаж, баталгаажуулан, сургалт зохион байгуулах чиглэлийг зохион байгуулагчид өгнө.

ТАВДУГААР БҮЛЭГ. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

5.1. Сургалт зохион байгуулагч нь дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллана:

5.1.1. хууль тогтоомж, Хорооноос баталсан журам, зааврыг мөрдөх;

5.1.2. мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн зах зээлийн нөхцөл байдал, гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө үндэслэл бүхий судалгаа шинжилгээнд суурилсан байх.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

6.1. Сургалт зохион байгуулагч гэрээний үүргийг зөрчсөн тохиолдолд Хороо гэрээг цуцалж, 1 жилийн хугацаанд тус байгууллагад сургалт зохион байгуулах эрх үүсэхгүй.

6.2. Сургалт зохион байгуулагч нь сургалт зохион байгуулах чадамжгүй болсон тохиолдолд Хороонөө дараагийн сургалт зохион байгуулагчийг сонгож, гэрээ байгуулна.

---oOo---

СУРГАЛТЫН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

№	Сургагч байгууллага	Овог	Нэр	Албан газар	Регистр	Цахим хаяг	Утасны дугаар

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТОВ

№	Эхлэх- дуусах цаг	Үргэлжлэх хугацаа	Сэдэв	Сургагч багшийн мэдээлэл	
				Байгууллага	Нэр